

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/08/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Товчилсон үгийн жагсаалт	3
Хүснэгтийн жагсаалт	3
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл.....	19
4.2 Материаллаг байдал.....	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Завсрын аудитын талаар.....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Залруулсан алдаа	21
5.2 Зөвлөмж	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	23
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	24

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт.....	16
Хүснэгт 2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	17
Хүснэгт 3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	18
Хүснэгт 4 Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт	18
Хүснэгт 5 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	20

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.08.15 № 01/52
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь ХААН банк дахь харилцах дансны орлого, зарлагын 100.4 мянган төгрөгийг тайлагнаагүй, өмнөх үеийн үр дүнгийн нийт орлогыг 1,387,000.0 мянган төгрөгөөр, төсвийн гүйцэтгэлийг 863.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн бараа материалын эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын дүнтэй тулгахад аж ахуйн материал 180.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 220.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,025,352,129.8	1,045,646,850.8
33	АВЛАГА	240,000.0	0.0
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	240,000.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	1,025,112,129.8	1,045,646,850.8
351	Түүхий эд материал	987,642,736.8	1,007,690,744.7
35110	Тусгай зориулалттай материал	987,642,736.8	1,007,690,744.7
354	Хангамжийн материал	37,469,393.0	37,956,106.1
35410	Бичиг хэргийн материал	1,732,369.1	1,621,235.1
35420	Аж ахуйн материал	3,499,898.3	3,240,266.0
35430	Сэлбэг хэрэгсэл	12,806,543.2	10,841,813.2
35440	Түлш, шатах тослох материал	1,029,340.0	1,911,250.0
35470	Бусад хангамжийн материал	18,401,242.4	20,341,541.8
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,334,278,802.6	1,298,755,873.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,334,278,802.6	1,298,755,873.4
392	Биет хөрөнгө	324,985,302.7	289,770,373.4
39201	Барилга, байгууламж, орон сууц	188,661,916.8	188,661,916.8
39202	Хуримтлагдсан элэгдэл	-27,384,794.3	-39,370,201.9
39203	Авто-тээврийн хэрэгсэл	65,267,573.8	56,267,573.8
39204	Хуримтлагдсан элэгдэл	-11,628,514.8	-16,880,272.2
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	103,510,489.4	119,307,479.4
39206	Хуримтлагдсан элэгдэл	-44,034,613.4	-61,559,251.8
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,243,040.0	10,243,040.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,849,070.2	-6,476,742.0
39214	Бусад үндсэн хөрөнгө	75,482,388.5	75,482,388.5
39215	Хуримтлагдсан элэгдэл	-30,283,113.2	-35,905,557.2
393	Биет бус хөрөнгө	1,009,293,500.0	1,008,985,499.9
39301	Програм хангамж	1,430,000.0	1,430,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-489,500.0	-797,500.1
39303	Бусад биет бус хөрөнгө	1,008,353,000.0	1,008,353,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,359,630,932.4	2,344,402,724.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,359,630,932.4	2,344,402,724.2
51	Засгийн газрын хувь оролцоо	2,359,630,932.4	2,344,402,724.2
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,343,813,362.6	1,343,813,362.6
51101	Өмч: - төрийн	1,343,813,362.6	1,343,813,362.6
512	Хуримтлагдсан үр дүн	988,098,115.7	972,869,907.4
51210	Өмнөх үеийн үр дүн	988,098,115.7	988,098,115.7
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	-15,228,208.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	27,719,454.2	27,719,454.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,359,630,932.4	2,344,402,724.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,541,104,007.4	1,562,524,518.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	95,456,748.4	73,446,936.4
120	Нийтлэг татварын бус орлого	95,456,748.4	73,446,936.4
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	95,456,748.4	73,446,936.4
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,203,344.0	120,000.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	94,253,404.4	73,326,936.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,445,647,259.0	1,489,077,582.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,410,392,400.0	1,481,559,800.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,410,392,400.0	1,481,559,800.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,254,859.0	7,517,782.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.0	0.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,882,459.0	4,679,032.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,372,400.0	2,838,750.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,507,448,786.4	1,573,627,726.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,437,343,711.4	1,482,956,723.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,437,343,711.4	1,482,956,723.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,124,867,900.0	1,183,306,015.6
210101	Үндсэн цалин	819,541,700.0	877,982,500.0
210102	Нэмэгдэл	274,110,000.0	274,110,000.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,216,200.0	31,213,515.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,857,200.0	147,913,600.0
210201	Тэтгэврийн даатгал	106,862,500.0	100,581,200.0
210202	Тэтгэмжийн даатгал	11,248,700.0	11,833,100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,998,900.0	9,466,500.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,249,700.0	2,366,600.0
210205	Эрүүл мэндийн даатгал	22,497,400.0	23,666,200.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,519,501.0	46,694,303.6
210301	Гэрэл, цахилгаан	27,854,401.0	29,154,266.0
210302	Түлш, халаалт	14,791,900.0	16,421,502.6
210303	Цэвэр, бохир ус	873,200.0	1,118,535.0
2104	Хангамж, бараа материалын зардал	25,869,786.1	24,606,771.1
210401	Бичиг хэрэг	952,960.0	918,816.0
210402	Тээвэр, шатахуун	12,123,632.0	13,193,278.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,722,014.0	3,344,220.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.0	260,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	934,985.7	1,088,981.3
210408	Бараа материал акталсны зардал	9,896,194.4	5,801,475.8

2105	Нормативт зардал	0.0	119,150.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.0	119,150.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,120.0	898,723.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.0	718,433.0
210604	Урсгал засвар	23,120.0	180,290.0
2107	Томилолт, зочны зардал	3,224,460.0	1,160,000.0
210702	Дотоод албан томилолт	3,224,460.0	1,160,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,696,852.5	30,903,749.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	55,965,842.5	26,350,671.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.0	604,800.0
210803	Даатгалын үйлчилгээ	412,600.0	303,800.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	220,510.0	182,400.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.0	88,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.0	484,000.0
210807	Газрын төлбөр	2,094,100.0	2,890,078.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,284,891.8	47,354,411.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	481,066.1	159,492.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,803,825.7	47,194,919.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,105,075.0	90,671,002.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,926,500.0	90,648,300.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	68,926,500.0	90,648,300.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,178,575.0	22,702.8
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,178,575.0	22,702.8
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	33,655,221.0	-11,103,208.3
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.0	4,125,000.0
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	0.0	4,125,000.0
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	33,655,221.0	-15,228,208.3

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,446,610,603.0	1,489,437,582.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	963,344.0	120,000.0
120	Нийтлэг татварын бус орлого	963,344.0	120,000.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	963,344.0	120,000.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	963,344.0	120,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,445,647,259.0	1,489,317,582.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,410,392,400.0	1,481,559,800.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,410,392,400.0	1,481,559,800.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,254,859.0	7,757,782.0
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.0	0.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	23,882,459.0	4,679,032.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,372,400.0	3,078,750.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,425,555,803.0	1,489,437,582.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,425,555,803.0	1,489,437,582.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,355,450,728.0	1,398,766,579.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,124,867,900.0	1,183,306,015.6
210101	Үндсэн цалин	819,541,700.0	877,982,500.0
210102	Нэмэгдэл	274,110,000.0	274,110,000.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,216,200.0	31,213,515.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,857,200.0	147,913,600.0
210201	Тэтгэврийн даатгал	106,862,500.0	100,581,200.0
210202	Тэтгэмжийн даатгал	11,248,700.0	11,833,100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,998,900.0	9,466,500.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,249,700.0	2,366,600.0
210205	Эрүүл мэндийн даатгал	22,497,400.0	23,666,200.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,519,501.0	46,694,703.6
210301	Гэрэл, цахилгаан	27,854,401.0	29,154,666.0
210302	Түлш, халаалт	14,791,900.0	16,421,502.6
210303	Цэвэр, бохир ус	873,200.0	1,118,535.0
2104	Хангамж, бараа материалын зардал	14,137,861.0	7,110,290.0
210401	Бичиг хэрэг	1,070,159.0	707,600.0
210402	Тээвэр, шатахуун	9,615,802.0	2,080,390.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,100,200.0	3,336,300.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.0	260,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,111,700.0	726,000.0
2105	Нормативт зардал	332,000.0	332,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	332,000.0	332,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	339,200.0	1,395,100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	166,400.0	916,900.0

210604	Урсгал засвар	172,800.0	478,200.0
2107	Томилолт, зочны зардал	3,224,460.0	1,160,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,694,747.0	10,695,378.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,963,737.0	6,142,300.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.0	604,800.0
210803	Даатгалын үйлчилгээ	412,600.0	303,800.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	220,510.0	182,400.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.0	88,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	300,000.0	484,000.0
210807	Газрын төлбөр	2,094,100.0	2,890,078.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	477,859.0	159,492.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	477,859.0	159,492.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,105,075.0	90,671,002.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,926,500.0	90,648,300.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	68,926,500.0	90,648,300.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,178,575.0	22,702.8
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	21,054,800.0	0.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	21,054,800.0	0.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	21,054,800.0	0.0
2200	Дотоод эх үүсвэрээр	21,054,800.0	0.0
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	21,054,800.0	0.0
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.0	0.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.0	0.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,343,813,362.6	48,249,342.0	933,913,007.0	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	20,529,887.7	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,343,813,362.6	48,249,342.0	954,442,894.7	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	33,655,221.0	-
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,343,813,362.6	27,719,454.2	988,098,115.7	-
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,343,813,362.6	27,719,454.2	988,098,115.7	-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,343,813,362.6	27,719,454.2	988,098,115.7	-
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(15,228,208.3)	-
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,343,813,362.6	27,719,454.2	972,869,907.4	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,484,453,700.0	1,481,657,097.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,484,453,700.0	1,481,657,097.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,391,011,500.0	1,391,008,797.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,183,308,700.0	1,183,306,015.6
210101	Үндсэн цалин	877,982,500.0	877,982,500.0
210102	Нэмэгдэл	274,110,000.0	274,110,000.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,216,200.0	31,213,515.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	147,913,600.0	147,913,600.0
210201	Тэтгэврийн даатгал	100,581,200.0	100,581,200.0
210202	Тэтгэмжийн даатгал	11,833,100.0	11,833,100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,466,500.0	9,466,500.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,366,600.0	2,366,600.0
210205	Эрүүл мэндийн даатгал	23,666,200.0	23,666,200.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,867,900.0	39,867,899.6
210301	Гэрэл, цахилгаан	24,402,100.0	24,402,100.0
210302	Түлш, халаалт	14,358,500.0	14,358,499.6
210303	Цэвэр, бохир ус	1,107,300.0	1,107,300.0
2104	Хангамж, бараа материалын зардал	7,110,300.0	7,110,290.0
210401	Бичиг хэрэг	707,600.0	707,600.0
210402	Тээвэр, шатахуун	2,080,400.0	2,080,390.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,336,300.0	3,336,300.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	260,000.0	260,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	726,000.0	726,000.0
2105	Нормативт зардал	332,000.0	332,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	332,000.0	332,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,295,100.0	1,295,100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	816,900.0	816,900.0
210604	Урсгал засвар	478,200.0	478,200.0
2107	Томилолт, зочны зардал	1,160,000.0	1,160,000.0
210702	Дотоод албан томилолт	1,160,000.0	1,160,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,864,400.0	9,864,400.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,142,300.0	6,142,300.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.0	604,800.0
210803	Даатгалын үйлчилгээ	303,800.0	303,800.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	182,400.0	182,400.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.0	88,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	484,000.0	484,000.0
210807	Газрын төлбөр	2,059,100.0	2,059,100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	159,500.0	159,492.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	159,500.0	159,492.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,442,200.0	90,648,300.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	93,442,200.0	90,648,300.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	93,442,200.0	90,648,300.0
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,484,453,700.0	1,481,679,800.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,484,353,700.0	1,481,559,800.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,484,353,700.0	1,481,559,800.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	100,000.0	120,000.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.0	120,000.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,757,782.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,757,782.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,757,782.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,826,804.00
210301	Гэрэл, цахилгаан	4,752,566.00
210302	Түлш, халаалт	2,063,003.00
210303	Цэвэр, бохир ус	11,235.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	830,978.00
210807	Газрын төлбөр	830,978.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,757,782.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,757,782.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,679,032.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,078,750.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь тайлант онд 98 орон тоогоор үйл ажиллагаагаа явуулахаар бүтэц орон тоо батлагдсанаас удирдах албан тушаалтан 1, гүйцэтгэх 90, үйлчлэх 7 нийт 98 орон тоогоор үйл ажиллагаа явуулж ажилласан байна.

Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлд "Ус цаг уур, орчны мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг шуурхай үйлчлэх, аюулт үзэгдэл, гамшиг, орчны бохирдлоос сэрэмжлүүлэх арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд цаг агаарын төлөв байдал, цаг уурын үзэгдэлд нөлөөлөх ажиллагаа явуулах, ус цаг уур, орчны төлөв байдлын талаар мэргэжлийн дүгнэлт гаргах, ус цаг уур, орчны хяналт шинжилгээнд дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэхэд чиглэсэн эрдэм шинжилгээ, туршилтын ажлыг зохицуулах" гэж заасны дагуу чиг үүргийг хэрэгжүүлдэг, БОАЯЖС-ын харьяа байгууллага юм.

Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг газар тариалангийн бүс нутгаар зонхилон 4 удаа гарч байрлан 10 удаа үйл ажиллагаа явуулж 23 ширхэг пуужин харваж Борнуур 0.2 мм, Цээл 3.2 мм, Аргалант 4.1 мм, Батсүмбэр 13.7 мм, бусад нутаг Дэлгэрхаан 2.4 мм-ээр нэмэгдүүлсэн ба цаг агаарын анхааруулах мэдээг 38 удаа, аюултай үзэгдлээс сэрэмжлүүлэх мэдээ 5 удаа цахим орчинд байршуулж мэдээлэхээс гадна 27 суманд 5 удаа "Багц мессеж"-ээр давхардсан тоогоор 41,146 хэрэглэгчдэд хүргэж ажилласан байна.

Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 бүлэг, 6 зорилт, 68 дэд зорилттой, хавсралт 1-ээр "Зохион байгуулах сургалтын төлөвлөгөө", хавсралт 2-оор "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө"-г баталсан байна. Жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтээ тус байгууллага 62 ажлыг 100 хувь, 5 ажлыг 95 хувь хувьтай гүйцэтгэсэн гэж дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуулийн 2022 оны 4 дүгээр сарын 22, 7 дугаар сарын 05, 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуулийг 2022 оны 5 дугаар сарын 01-ээс шинээр мөрдөгдөж эхэлсэн,
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг 2022 оны 5 дугаар сарын 01-ээс шинээр мөрдөгдөж эхэлсэн,
- Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 7 дугаар зүйлд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль

тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн "Дотоод хяналт, шалгалтын комисс"-ыг А/12 дугаар тушаалаар Цаг уур, орчны технологийн хэлтсийн дарга бөгөөд архив мэдээллийн дэд сангийн зохицуулагч Г.Гэрэлцэцэгээр ахлуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн томилсон байна.

Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дотоод хяналт шалгалтын комисс нь тайлант онд дотоод хяналт шалгалт явуулахаар 20-21 арга хэмжээг улирлаар төлөвлөн захиргаа, төсөв санхүү, албаны үйл ажиллагаанд хийж 4 чиглэлээр зөвлөмжийг хүргүүлэн хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Тус байгууллагад тайлант онд ЦУОШГ-ын Нислэгийн цаг уурын төвийн дотоод хяналт, чанарын алба 2022 оны 5 сард нислэгийн цаг уурын үйлчилгээний ажилд төлөвлөгөөт үзлэг, шалгалт хийж 6 зөвлөмж, 3 шаардлага хүргүүлсэн байна. Мөн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба Төв аймагт ажилласан ажлын тайланд усан хангамж, усан сан бүхий газрын хамгаалалт бүсийн дэглэм, хог хаягдлын талаар дурдсан байна. Нислэгийн цаг уурын төвд 2022 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 117 дугаар албан бичгээр шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хүргүүлсэн байна.

Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ЦУОШГ-ын даргын 2020 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн А/170 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг 2020 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн байна. Энэхүү баримт бичигт ус цаг уурын салбарын бүртгэл тайлагналын онцлог гэсэн 5 дэд бүлэгт бүртгэлийн үйл ажиллагааг тусгасан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,228.2 мянган төгрөгөөр буюу 99,4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	240.0	-	(240.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	1,025,112.1	1,045,646.9	20,534.7
Үндсэн хөрөнгө	1,334,278.8	1,298,755.9	(35,522.9)
Нийт хөрөнгө	2,359,630.9	2,344,402.7	(15,228.2)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,359,630.9	2,344,402.7	(15,228.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,359,630.9	2,344,402.7	(15,228.2)

Дээрх хүснэгтээс харахад: Бараа материал дансны хувьд тусгай зориулалтын материал 20,048.0 мянган төгрөг, түлш, шатах тослох материал 881,910.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 1,940,299.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, бичиг хэргийн материал 111,134.0 мянган төгрөг, аж ахуйн материал 259,632.0 мянган төгрөг, сэлбэг хэрэгсэл 1,964,730.0 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс 2022 онд машин тоног төхөөрөмж 15,797.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, шилжүүлсэн 9,000.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан 15,797.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,344,403.0 мянган төгрөг болж 15,228.0 төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,086,034.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Ус, цаг уур орчны шинжилгээний газраас төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,484,453.7 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр батлан ирүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 601,581.0 мянган төгрөгөөр бууруулж улсын төсвөөс 1,484,353.7 мянган төгрөгөөр, төсвийн байгууллагын үйл ажиллагааны өөрийн орлогоос 100.0 мянган төгрөг байхаар баталж ирүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,484,353.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 100.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр нийт 1,484,679.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,481,559.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, төсөвт байгууллагын үйл ажиллагааны өөрийн орлого 120.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захиаргчаас 4,679.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 3,078.7 мянган төгрөг орж, нийт 1,489,437.5 мянган төгрөгийг бүрдүүлж 22,7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,489,414.8 мянган төгрөг буюу бараа үйлчилгээний урсгал зардал 1,398,766.6 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн 90,648.3 мянган төгрөгийг зарцуулж, 22.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Ус цаг уур, орчны шинжилгээ-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,384,869.2	1,384,866.5	2.7	99,9
2	Ус цаг уур, орчны шинжилгээ-Холбооны суваг ашигласны хөлс	6,142.3	6,142.3	-	100,0
3	Ус цаг уур, орчны шинжилгээ-Ажил олгогчоос олгох тэтгэмж	93,442.2	90,648.3	2,793.9	97,0
	Дүн	1,484,453.7	1,481,657.1	2,796.6	99,9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 4,679.0 мянган төгрөгөөр, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 3,078.7 мянган төгрөгөөр нийт 7,757.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар гэрэл цахилгаан 4,752.6 мянган төгрөг, түлш халаалт 2,063.0 мянган төгрөг цэвэр бохир ус 11.2 мянган төгрөг, багаж техник хэрэгсэл 100.0 мянган төгрөг, газрын төлбөрт 830.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Ус цаг уур, орчны шинжилгээ-	7,757.8	7,757.8	-	100
	Дүн	7,757.8	7,757.8	-	100

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 3 хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 4 Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	71408 80101	2022.01.01- 2022.12.31	Үндсэн үйл ажиллагаа	Эрдэм шинжилгээний судалгаа 99,99 %	1,392,627.0	1,392,624.3
2	71408 80220	2022.01.01- 2022.12.31	Мэдээлэл солилцоо	Холбооны суваг ашигласны 100%	6,142.3	6,142.3
3	71408 80835	2022.01.01- 2022.12.31	Урсгал шилжүүлэг	Төрийн албан хаагчдад олгох мөнгөн тэтгэмж 97%	93,442.2	90,648.3

Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн нийгмийн хамгааллын дэмжих хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдад тэтгэвэр гарахад олгох мөнгөн тэтгэмжийг гүйцэтгэлд суурилан санхүүжилтийн хүсэлтийг холбогдох материалын хамт албан бичгээр хүргүүлэн олгогдож байсан холбоотой байна.

Байгууллагын төрийн үйлчилгээний албан хаагчдад 98 орон тоогоор батлагдсан.

Хүний нөөцийн нөхөн бүрдүүлэлтийн олон нийтийн зард мэдээлэл хүргэн албан хаагчдыг сонгон шалгаруулалт хийж төрийн үйлчилгээний албан хаагчдын боловсон хүчний асуудлыг шийдвэрлэж байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгөгдсөн зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 01/08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн, суурь үзүүлэлтийг нийт орлого 1,562,524.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 23,116.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 18,493.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь тайлант онд төсвийн хэмнэлтийн талаарх ЦУОШГ-аас өгсөн чиглэлийн дагуу гэрэл цахилгаан, түлш халаалт, урсгал засвар, шуудан холбоо интернэтийн зардал, дотоод томилолтын зардал, тээвэр шатахууны зардлуудыг 8 хувиар бууруулан ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 100 хувьтай, 5.0 саяас дээших орлогын 15 гүйлгээ, зарлагын 4 гүйлгээ, 5.0 саяас дээших худалдан авалттай холбоотой 5 гүйлгээ хугацаандаа байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2022 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн тайланд аудитын урьдчилсан болон төлөвлөлтийн үе шатны ажлыг гүйцэтгэж, байгууллагын мөрдөж ажилладаг хууль тогтоомжийн хэрэгжилт, ирсэн явсан бичиг, даргын тушаал, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилттэй танилцаж эрсдэлээ тодорхойлсон.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй дүгнэлт авсан аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 01/97 дугаарын албан бичгээр ирүүлсэн.

Хүснэгт 5 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	3	10,223.8	3	10,223.8	100
Зөвлөмж	1	2,135.2	1	2,135.2	100
Нийт дүн	4	12,369.0	4	12,369.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн агаар мандал, усан мандал, хөрсний шинжилгээний үйл явц, түүнд тавих хяналт гэрээ, орлогыг авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 1,397,083.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,396,683.4 мянган төгрөгийн алдааг залрууллаа.Үүнд:

Тус байгууллага тайлант онд ХААН банк дахь харилцах дансны орлого, зарлагын 100.4 мянган төгрөгийг тайлагнаагүй, өмнөх үеийн үр дүнгийн нийт орлогыг 1,387,000.0 мянган төгрөгөөр, төсвийн гүйцэтгэлийг 863.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Цаг уур орчны шинжилгээний газрын даргын 2022 оны 12 сарын 23-ны өдрийн А/238 дугаар тушаалаар олгосон 4,679.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд бүртгэхдээ орлогоор бүртгэлгүй өглөг дансанд бүртгэсэн, үйл ажиллагааны хүрээнд бий болсон давсан орлого 3,078.8 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд шилжүүлж бүртгэхдээ орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн, түлш халаалт, гэрэл цахилгааны 962.2 мянган төгрөгийн төлбөрийг нэхэмжилсэн дүнгээр бүртгэж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 400.0 мянган төгрөгийн илэрсэн зөрчилд² зөвлөмж өглөө.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн бараа материалын эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын дүнтэй тулгахад аж ахуйн материал 180.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 220.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана." санхүүгийн тайлангийн аудитын "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийн тооллогыг чанартай хийж, тооллогын бүртгэлтэй санхүүгийн тайлангийн дансны үлдэгдэлтэй тулган баталгаажуулж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Арилжааны банк дахь харилцах дансны орлого, зарлагын 100.4 мянган төгрөг тайлагнаагүй байна.	1	100.4	1	100.4			1	100.4
2022 оны 4-р улирлын үр дүнгийн тайлангийн өмнөх үе нь аудит хийгдсэн 2021 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангаас нийт орлого 1,387,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	1,387,000.0			1	1,387,000.0	1	1,387,000.0
2022 оны 4-р улирлын Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн өмнөх үеийн батлагдсан төлөвлөгөөний нийт зардал нь аудит хийгдсэн 2021 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаас гүйцэтгэл 863.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	863.3			1	863.3	1	863.3
Цаг уур орчны шинжилгээний газрын даргын 2022 оны 12 сарын 23-ны өдрийн А/238 дугаар тушаалаар олгосон санхүүгийн дэмжлэгийг нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд бүртгэхдээ орлогоор бүртгэлгүй өглөг дансанд бүртгэсэн байна.	1	4,679.0			1	4,679.0	1	4,679.0
Үйл ажиллагааны хүрээнд бий болсон давсан орлогыг нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд шилжүүлж бүртгэхдээ орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн	1	3,078.8			1	3,078.8	1	3,078.8
Түлш халаалт, гэрэл цахилгааны төлбөрийг нэхэмжилсэн дүнгээр бүртгэж тайлагнаагүй	1	962.2			1	962.2	1	962.2
Дүн	6	1,396,683.6	1	100.4	5	1,396,583.3	6	1,396,683.6

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс		
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж
Санхүүгийн тайлангийн бараа материалын эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын дүнтэй тулгахад аж ахуйн материал 180.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 220.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	400.0			400.0
Дүн	400.0	-		400.0